# НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 06 өдөр Дугаар А/04 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн 5, 6 дугаар зүйл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8, 35 дугаар зүйл, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын "2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг тухай бүр гаргахыг холбогдох албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (С.Оюунцэцэг)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХТАЙВАН

9022020284
5664225 СБТ17758

D:\Gargah\2023\1-27\a tushaal\A4.doc

1150500983

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн ....А/04.... дугаар тушаалын хавсралт

9022020283
5664225 СБТ17759

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 01 дүгээр сарын 05 Улаанбаатар хот

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Суурь түвшин | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хүрэх түвшин үр дүн | Хөрөнгийн эх үүсвэр, зарцуулах мөнгөн дүн | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Зорилго 1: Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | | | | |
| 1 | 1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; | Жилдээ | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн видео график, нийтлэл, хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк)-түгээсэн. Үүнд:<br>Ном, гарын авлага-1<br>2022-05-09-“Авлигын эсрэг үндэсний чуулган-2021” илтгэлүүдийн эмхэтгэл,<br>-Хэвлэмэл материал сурталчилгаа-1<br>2022-03-15-Авлигатай тэмцэх үйл ажиллагаа дэлхий дахинд<br>-Видео мэдээ-13<br>Байгууллагын цахим хуудасд байршуулсан видео мэдээг давхардсан тоогоор 466 удаа, цахим ном гарын гарын авлага зэргийг давхардсан тоогоор | -Баримтжуулсан байх<br>-Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)<br>-Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадад мэдээллийг хүргүүлсэн байх. | Авлигын эсрэг мэдээллийг иргэд олон нийтэд ил тод мэдээлсэн байна. | - | ЭБАТ |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 146 удаа үзсэн байна. Тус газрын албан ёсны олон нийтийн сүлжээний фэйсбүүк хуудсаар түгээсэн шторк, инфографик, зурагт хуудас 654 удаа үзсэн байна. | | | | |
| 2 | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах; | Жилдээ | Тус газрын 30 албан хаагч Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төв болон Авлигатай тэмцэх газрын цахим хуудсанд нэгдэж, мэдээ, мэдээллийг тухай бүр олон нийтэд түгээн ажиллаж байна.<br>"Зөв зөвд шударга зөв" аяны хүрээнд гарсан мэдээлэл, сурталчилгааны материалыг байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсаар дамжуулан нийт албан хаагчид тухай бүр түгээж ажилласан. | -2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>-Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх. | Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын хэмжээнд зохион байгуулан ажилласан байна. | - | ЭБАТ, ХЭЗХ, Нийт албан хаагчид |
| 3 | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах; | Жилдээ | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах зорилгоор "Шударга ёс, хөгжилд дэвшилд 110" мэдээллийг самбарыг 520,000 төгрөгөөр хийлгүүлсэн бөгөөд мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн ажиллаж байна. | -Мэдээллийг сар бүр шинэчлэх;<br>-Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх. | Байгууллагад мэдээллийн самбар байршуулж, мэдээллийг тогтмол шинэчилж хэвшсэн байна. | - | ЭБАТ |
| 4 | 1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, | Жилдээ | Тус газрын 30 албан хаагч Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төв болон Авлигатай тэмцэх газрын цахим хуудсанд нэгдэж, мэдээ, мэдээллийг тухай бүр олон нийтэд түгээн | -2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх;<br>-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон | Иргэд олон нийтэд хүргэсэн байна. | - | ЭБАТ, Ёс зүйн зөвлөл, ХЭЗХ, МТХ. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх. | | ажиллаж байна.<br>“Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд гарсан мэдээлэл, сурталчилгааны материалыг байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсаар дамжуулан нийт албан хаагчид тухай бүр түгээж ажилласан. | нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;<br>Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх. | | | |
| Зорилго 2: Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | | | | | | | |
| 5 | 2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх; | 4 дүгээр улиралд | 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор 46 албан хаагчийг хамруулсан | -Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байна. | - | ЭБАТ |
| 6 | 2.2. Тендерт оролцогч Аж ахуйн нэгж байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах. | Тухай бүр | - | -Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Иргэд олон нийтэд сурталчилсан байна. | - | ЭБАТ, МТХ. |
| Зорилго 3: Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | | | | | | | |
| 7 | 3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас | | Тус газраас хувийн хэвшилтэй байгуулсан 12 гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх | -Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажилласан байна. | - | ХЭЗХ, Ахлах нягтлан бодогч |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх; | | заалтыг тусган ажилласан. | -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх;<br>-Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах;<br>-Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | | | Нийт албан хаагчид |
| 8 | 3.2.Монгол улсын Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх | Жилдээ | - | -Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх;<br>-Сургалт, мэдээлэл авсан байх;<br>-Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх. | Журмын хэрэгжилт хангагдсан байна. | - | ХЭЗХ, Дотоод аудитор, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн |
| Зорилго 3: Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | | | | | | | |
| 9 | 4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/ | Жилдээ | Үйлчилгээг цахимжуулах зорилгоор Төрийн Худалдан авах ажиллагааны газрын цахим систем (www.tender.gov.mn)-д холбосон эрх бүхий 8 байгууллагын 9 баталгаажсан лавлагаа, тодорхойлолтыг үндэслэн үнэлгээнд ашиглаж, тендер шалгаруулалтад хүний оролцоог бууруулан ажиллаж байна. | -Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх ; | | - | ЭБАТ, ТХААХ, ХЭЗХ, МТХ. |
| 10 | 4.2.Салбарын хэмжээнд | | Монгол Улсын Сангийн яам, | -2-оос доошгүйг зохион | | - | ЭБАТ, |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх; | | Төрийн худалдан авах ажиллагааны газар, Авлигатай тэмцэх газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар хамтарсан уулзалтыг 2022 оны 09 сарын 05-ны өдөр Нийслэлийн Засаг захиргааны тавдугаар байр, Иргэний танхимд зохион байгуулсан | байгуулсан байх;<br>-Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх | | | ТХААХ, ХЭЗХ, МТХ. |
| 11 | 4.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах. | | - | -Бодитой үр дүнг тооцсон байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх | Сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулсан байна. | - | ЭБАТ, Дотоод аудитор, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн |
| Зорилго 5: Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | | | | | | | |
| 12 | 5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах; | I, II, IV улирал | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг 3 удаа нийт албан хаагчдын хуралд танилцуулсан. | -Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>-Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх;<br>-Арга хэмжээнд удирдлагын<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Албан хаагчид болон иргэдийн авлигын талаарх мэдлэг дээшилсэн байна. | - | ХЭЗХ, ТХААХ, ЭБАТ, Нийт албан хаагчид. |
| 13 | 5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал; | Тухай бүр | - | -Санал тусгасан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Саналаа тухай бүр тусгаж ажилласан байна. | - | ЗСХ, ХЭЗХ. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | 5.3.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллах | III улирал | Монгол Улсын Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Авлигатай тэмцэх газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар хамтарсан уулзалтыг 2022 оны 09 сарын 05-ны өдөр Нийслэлийн Засаг захиргааны тавдугаар байр, Иргэний танхимд зохион байгуулсан. | -Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх;<br>-Тайлагнасан байх. | Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан байна. | - | ЭБАТ, ХЭЗХ. |
| | 5.3.1.Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д холбогдсон эрх бүхий байгууллагын баталгаажсан лавлагаа, тодорхойлолтыг үндэслэн тендер шалгаруулалтын үнэлгээнд ашиглаж, тендер шалгаруулалтад хүний оролцоог бууруулах | Жилдээ | Үйлчилгээг цахимжуулах зорилгоор Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д холбосон эрх бүхий 8 байгууллагын 9 баталгаажсан лавлагаа, тодорхойлолтыг үндэслэн үнэлгээнд ашиглаж, тендер шалгаруулалтад хүний оролцоог бууруулан ажиллаж байна. | Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д холбогдсон эрх бүхий байгууллагын баталгаажсан лавлагаа, тодорхойлолтын тоо | Тендерийг цахим системээр зохион байгуулж, үнэлгээнд хүний оролцоог бууруулсан байна. | - | ТХААХ, Дотоод аудитор |
| | 5.3.2.өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх; | Жилдээ | Тайлант хугацаанд 57 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд үндэслэлтэй шийдвэрлэж, тухай бүр хариу өгч ажилласан бөгөөд ННҮТ-д 4 удаа тайланг хүргүүлсэн. | Нийслэлийн Дотоод удирдлагын нэгдсэн UB ERP системээр Иргэдээс, аж ахуйн нэгж, албан хаагчдаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулсан байх | - | ЗСХ, ХЭЗХ, Өргөдөл хүлээн авсан албан хаагч. |
| | 5.3.3.Төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах, Төрийн хэмнэлтийн тухай | Жилдээ | Төсөв, санхүүгийн сахилга баттай ажиллаж, НДТАГ-ын дүгнэлтээр зөрчилгүй санал | Төлөвлөгөө боловсруулан батлуулах, | Аудитын шалгалтаар зөрчилгүй санал | - | Ахлах нягтлан бодогч, |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хууль, Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, | | дүгнэлт авсан. | хэрэгжилтийг хангаж ажиллах,<br>Төсөв, санхүүгийн сахилга баттай ажиллах. | дүгнэлт авсан байна. | | Нийт албан хаагчид |
| | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалт зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах. | I, III улиралд | Монгол Улсын Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Авлигатай тэмцэх газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар хамтран "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт"-ийн талаарх сургалт, уулзалтыг 2022 оны 09 сарын 05-ны өдөр Нийслэлийн засаг захиргааны тавдугаар байр, Иргэний танхимд зохион байгуулж, нийт 180 гаруй албан хаагчийг хамруулсан. | -2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна.<br>-Тухай бүр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн байна. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчид авах ажиллагааны чиглэлээр мэдлэг мэдээлэлтэй болсон байна. | - | МТХ, ТХААХ |
| | "Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам"-ын хэрэгжилтийг хангуулж, Шалгарсан тендерт оролцогчийн материалыг гэрээ байгуулах эрх олгосон өдөртөө багтаан Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан тухайн тендерт оролцогчдод ил тод мэдээлэх; | Жилдээ | Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) нийтлэн тухайн тендерт оролцогчдод шалгарсан тендерт оролцогчийн материалыг ил болгон мэдээлсэн. | Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д тухай бүр нийтэлсэн байна. | Журмын хэрэгжилтийг хангуулж ажилласнаар Тендерт оролцогчид тухайн тендер шалгаруулалт шударга явагдсан эсэхэд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн байна. | - | ТХААХ |
| | Үнэлгээний хороонд томилогдсон гишүүн бүр "Ашиг | | Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажилласан | Цахим хуудаст тухай бүр шивсэн байна. | Ашиг сонрхлын зөрчлөөс ангид | | ТХААХ, ЭБАТ |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийн загварын дагуу бөглөсөн байх; | | албан хаагчдаас хүлээн авсан 410 "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг тухай бүр хянан хүлээн авч Авлигатай тэмцэх газрын системд болон Шилэн дансны системд мэдээлж" ажилласан. | Тухайн худалдан авах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчилтэй эсэх мэдэгдлийг бүрэн бөглүүлж, шилэн данс болон Авлигатай тэмцэх газрын системд бүрэн шивсэн байх. | ажилласан байх. | | |
| | Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хууль тогтоомжийн дагуу хөндлөнгийн төлөөллийг оролцуулсан байх; | | ТББ-ын 195, иргэний төлөөлөл 8, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл 3 оролцуулж, хөндлөнгийн хяналтыг ханган ажилласан. | Мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагын төлөөллийн тоо | Үнэлгээний хороо бүрт хөндлөнгийн төлөөллийг оролцуулж_ хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байх | | ТХААХ, ХЭЗХ. |
| | Байгууллагаас батлан гаргаж буй, тушаал, шийдвэрийн үндэслэлийг сайжруулах | Жилдээ | 2022 онд А тушаал 1-114, Б тушаал 1-123 тушаалыг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаан ажилласан. | Хууль тогтоомжийг оновчтой үндэслэн тушаал шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангаан ажиллах. | Тушаалын үндэслэх хэсэгт хамааралгүй хууль тогтоомжийг үндэслэхгүй байх, Тушаалын хэрэгжилт, үр дүнг тооцсон байх. | | ХЭЗХ, Дотоод аудитор, Холбогдох албан хаагчид |
| | Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм журам нь НИТХ-ийн тогтоол, Засаг даргын захирамж, Засгийн газрын тогтоолоор хүчин төгөлдөр болсон эсэхэд Хяналь, шинжилгээ шнэлгээ хийх | III улирал | - | Хүчин төгөлдөр бус дүрэм журмыг хүчингүй болгосон байна. | Хууль тогтоомжийн дагуу дүрэм журмыг боловсруулан мөрдүүлсэн байна. | | ХЭЗХ, Ажлын хэсэг, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн. |

-.oOo -